

ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ НАРЫН 2021 ОНЫ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /цаашид “хууль” гэх/-ийн 49 дүгээр зүйлийн 49.7 дахь хэсэг, Сангийн сайдын 2021 оны 102 дугаар тушаалаар шинэчлэн баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам” /цаашид “журам” гэх/-ын 5 дугаар хэсэгт заасны дагуу Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2021 оны худалдан авах ажиллагааны хэрэгжилтийг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем /www.tender.gov.mn/-д нийтэлсэн төлөвлөгөө, тендер шалгаруулалтын явц, тендер шалгаруулалтын урилга, үр дүн болон гомдлын судалгаанд үндэслэн нэгтгэн дүгнэсэн болно.

Журам шинэчлэн баталсантай холбогдуулан төсвийн ерөнхийлөн захирагч нарын тайланд үнэлгээ өгч дүгнээгүй бөгөөд журмын 5.2 зааснаар Сангийн яамны худалдан авах ажиллагааны бодлогын нэгж нь 2021 оны худалдан авах ажиллагааны тайланг цахим системээр хүлээн авч 50 төсвийн ерөнхийлөн захирагч нарын худалдан авах ажиллагаанд хяналт, шинжилгээ хийж, цаашид анхаарах асуудлын талаар зөвлөмж хүргүүлсэн.

Худалдан авах ажиллагааны төлөвлөсөн байдал:


Хуулийн 48 дугаар зүйлийн 48.5 дахь хэсэгт зааснаар нийт 2,694 захиалагч бүртгүүлснээс 512 захиалагч худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг тухайн жилийн төсөв батлагдсанаас хойш нэг сарын дотор хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлан мэдээлж ажилласан байна.

Цахим системийн мэдээллээс үзэхэд Нийслэлийн Засаг даргын багцын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 172 удаа, Эрүүл мэндийн сайдын багцын төлөвлөгөөнд 122 удаа, Боловсрол, шинжлэх ухааны сайдын багцын төлөвлөгөөнд 98 удаа, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын харьяа байгууллагуудын төлөвлөгөөнд 71 удаа өөрчлөлт оруулсан байна. Төлөвлөгөөнд байнга өөрчлөлт оруулах нь худалдан авах ажиллагааг зохион байгуулахад хугацаа алдах, улмаар төсвийн жил дамжих, улирлын чанартай ажлын хувьд хэрэгжихгүй байх сөрөг талтай байдаг.

Худалдан авах ажиллагааны холбогдох журмыг баримталсан байдал:

Цахим системээр 1,416 захиалагч нийт 21,739 тендерийн урилгыг зарласан байна. Нийт 84.5 хувь буюу 8.8 их наяд төгрөгийн худалдан авах ажиллагааг нээлттэй тендер шалгаруулалтын журмаар, 2.9 хувь буюу 306.6 тэрбум төгрөгийн худалдан авах ажиллагааг харьцуулалтын аргаар, 1.8 хувь буюу 192.3 тэрбум төгрөгийн худалдан авах ажиллагааг хязгаарлагдмал тендер шалгаруулалтын аргаар, 7.1 хувь буюу 746 тэрбум төгрөгийн худалдан авах ажиллагааг гэрээ шууд байгуулах аргаар, 0.54 хувь буюу 56.3 тэрбум төгрөгийг шууд худалдан авалтаар, 2.9 хувь буюу 301.3 тэрбум төгрөгийг зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч сонгон шалгаруулах журмаар, 0.02 хувь буюу 2.08 тэрбум төгрөгийн худалдан авах ажиллагааг олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны журмаар тус тус зохион байгуулсан байна.

Худалдан авах ажиллагааны журмыг хэрэглэсэн байдал /хувиар/



Төсвийн ерөнхийлөн захирагчдын бараа, ажил, үйлчилгээ худалдан авсан тухай 2021 оны нэгдсэн тайлангаас үзэхэд Монгол Улсын хэмжээнд төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр нийт 10.4 их наяд төгрөгийн төсөвт өртөгтэй тухайн онд санхүүжих дүн нь 6.1 их наяд төгрөгийн худалдан авалт зохион байгуулснаас 7.4 их наяд төгрөгийн худалдан авалтыг төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдээс зохион байгуулсан байна. Хамгийн өндөр өртөгтэй 2,229.28 тэрбум төгрөгийн төсөвтэй тендер шалгаруулалтыг “Эрдэнэс Тавантолгой” ХК-аас зарласан “Цанхийн зүүн уурхайн гэрээт олборлогч”-ийг сонгох тендер шалгаруулалт байна.

Тэрбум төгрөг

| ЗАХИАЛАГЧИЙН НЭР | ДУГААР | ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН НЭР | ТӨСӨВТ ӨРТӨГ | ТУХАЙН ОНД САНХҮҮЖИХ ДҮН |
|---------------------------------|-------------------|--|--------------|--------------------------|
| “Эрдэнэс Тавантолгой” ХК | ЭТТ/202102386 | Цанхийн зүүн уурхайн гэрээт олборлогч | 2,229.28 | 62.20 |
| “Эрдэнэс Тавантолгой” ХК | ЭТТ/202108508 | Нүүрс баяжуулах үйлдвэрийн барилгын зураг төсөв боловсруулах, барилга угсралтын ажил гүйцэтгэх | 956.45 | 956.45 |
| “Эрдэнэс Тавантолгой” ХК | ЭТТ/202102388 | Бортээгийн уурхайн гэрээт олборлогч | 715.96 | 42.00 |
| “Эрдэнэс Тавантолгой” ХК | ЭТТ/202102387 | Цанхийн зүүн уурхайн өрөмдлөг, тэсэлгээ | 239.10 | 7.83 |
| Улаанбаатар төмөр зам нийгэмлэг | УБТЗХНН/202109601 | Илчит тэрэгний өвөл, зуны дизелийн түлш худалдан авах | 211.35 | 211.35 |

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын худалдан авах ажиллагааны талаар:

Монгол Улсын 2021 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх шинээр эхлэх нийт 458 төсөл, арга хэмжээнд 949.2 тэрбум төгрөг батлагдаж 2021 онд 478.3 тэрбум төгрөгийн санхүүжилт олгохоос 410.4 тэрбум төгрөгийн санхүүжилт олгож, гүйцэтгэл 85.8 хувьд хүрсэн байна.

Хуулийн 45 дугаар зүйлийн 45.5 дах хэсэгт заасны дагуу Монгол Улсын 2021 оны төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх төсөл, арга хэмжээнээс төсвийн жилд Засгийн газрын худалдан авах ажиллагааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын хэрэгжүүлэх улсын болон бүс нутгийн чанартай төсөл, арга хэмжээний жагсаалтыг Засгийн газрын 2021 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 15 тогтоолоор баталсан.


Дээрх тогтоолоор төсвийн ерөнхийлөн захирагч 434.2 тэрбум төгрөгийн 126 төсөл, арга хэмжээ, Төрийн худалдан авах ажиллагааны газар 265.6 тэрбум төгрөгийн 121 төсөл, арга хэмжээ, орон нутагт 254.1 тэрбум төгрөгийн 211 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар хуваарилсан байна.

Монгол Улсын 2021 оны төсвийн хөрөнгө
оруулалтаар санхүүжүүлэх шинээр эхлэх
төсөл, арга хэмжээний нэгдсэн хүснэгт

| Төсвийн ерөнхийлөн захирагч | Төсөл, арга хэмжээ | Төсөвт өртөг | Сая төгрөг |
|---|--------------------|-------------------|-------------------|
| | | | Санхүүжих дүн |
| БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД | 112 | 185,247.70 | 72,041.40 |
| БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙД | 89 | 114,407.70 | 50,107.50 |
| ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД | 51 | 164,152.40 | 138,326.10 |
| ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙД | 34 | 83,664.10 | 30,562.20 |
| ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД | 28 | 38,523.40 | 17,447.00 |
| СОЁЛЫН САЙД | 27 | 74,734.00 | 28,122.70 |
| МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА | 25 | 51,257.20 | 12,646.00 |
| ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД | 22 | 30,564.70 | 9,802.40 |
| ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД | 16 | 40,869.80 | 15,600.50 |
| ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД | 14 | 28,924.70 | 9,804.70 |
| МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД | 13 | 34,615.00 | 8,015.00 |
| БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД | 7 | 5,148.00 | 2,348.00 |
| УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР | 5 | 14,961.30 | 12,624.30 |
| ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД | 2 | 4,349.40 | 4,349.40 |
| АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ДАРГА | 2 | 1,150.00 | 1,150.00 |
| БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД | 2 | 1,600.00 | 1,600.00 |
| ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛ | 2 | 4,000.00 | 4,000.00 |
| САНГИЙН САЙД | 2 | 69,000.00 | 69,000.00 |
| МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД | 1 | 100.00 | 100.00 |
| МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА | 1 | 1,066.60 | 1,066.60 |
| МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА | 1 | 3,570.30 | 3,570.30 |
| МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР | 1 | 1,497.30 | 1,497.30 |
| САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГА | 1 | 492.50 | 492.50 |
| Grand Total | 458 | 953,896.10 | 494,273.90 |


Монгол Улсын 2021 оны төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх 40.5 тэрбум төгрөгийн 12 төсөл, арга хэмжээг хуулийн 3 дугаар зүйлийн 3.4 дэх хэсэгт заасны дагуу төрийн нууцад хамаарах тул тендер шалгаруулалтыг зохион байгуулаагүй байна. Сангийн сайдын багцаас санхүүжүүлэх Гадаадын зээл,

тусламжаар хэрэгжих төслүүдийн Монголын талын хөрөнгө оруулалт /Улсын хэмжээнд/, "Хөгжлийн хөтөч-Дэд бүтэц" төсөл, хилийн боомтын дэд бүтцийн хүрээнд хийгдэх ажлын техник, эдийн засгийн үндэслэл, зураг, төсөв /Улсын хэмжээнд/ төсөл, арга хэмжээ хүрээнд худалдан авах ажиллагааг тухайн зээлийн хэлэлцээрийн хүрээнд зохион байгуулсан байна.



Эхний тендер шалгаруулалтыг 2021 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр зарласан байна. Нийт 711.9 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 339 буюу төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг нээлттэй тендер шалгаруулалтын журмаар, 123.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 83 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг тендер шалгаруулалтын онцгой журмаар, 8.7 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 21 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг зөвлөх үйлчилгээ гүйцэтгэх журмаар, 10 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 шууд худалдан авалт зохион байгуулсан байна.

Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжигдэх төсөл, арга хэмжээг зохион байгуулсан худалдан авах ажиллагааны журам



Шинээр эхлэх төсөл, арга хэмжээ эдийн засгийн ангиллаар

Тэрбум төгрөг

| Ангилал | Нийт | Төсөвт өртөг | Санхүүжих дүн |
|-----------------------|---------------|---------------|---------------|
| I. Барилга байгууламж | 257.00 | 658.50 | 239.87 |
| II. Их засвар | 88.00 | 59.26 | 52.31 |
| III. Тоног төхөөрөмж | 89.00 | 112.42 | 79.28 |
| IV. ТЭЗҮ | 23.00 | 13.72 | 12.82 |
| Нийт | 457.00 | 843.90 | 384.27 |

Монгол Улсын 2021 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх шинээр эхлэх нийт 458 төсөл, арга хэмжээнээс 52.2 тэрбум төгрөгийн 30 төсөл, арга хэмжээ санхүүжилт аваагүй байна. Төсвийн ерөнхийлөн захирагчдаас ирүүлсэн мэдээллээс үзэхэд 2021 онд шинээр эхлэх барилга байгууламжийн 257 төсөл, арга хэмжээнээс 12 төсөл, арга хэмжээ газаргүй байсан байна.

Газрын асуудал шийдэгдээгүй 2021 онд шинээр эхлэх төсөл, арга хэмжээний жагсаалт

| Хуулийн дугаар | Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил | ТӨЗ | Төсөвт өртөг | Санхүү-жигдэх дүн |
|----------------|---|------|--------------|-------------------|
| XII.1.94 | Эко ногоон байгууламж /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 10, 12, 16, 17, 19 дүгээр хороо/ | БХБС | 2,000 | 700 |
| XIII.1.1.272 | Архангай аймгийн оюутны дотуур байрын спорт заалны барилга /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/ | БШУС | 750 | 750 |
| XIII.1.1.243 | Цэцэрлэгийн барилга, 100 ор /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 16 дугаар хороо/ | БШУС | 1,400 | 420 |
| XIII.1.1.240 | Цэцэрлэгийн барилга, 150 ор /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 7 дугаар хороо/ | БШУС | 1,750 | 500 |
| XIII.1.1.239 | Тусгай хэрэгцээт хүүхдийн цэцэрлэгийн барилга /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/ | БШУС | 4,000 | 500 |
| XIII.1.1.235 | Цэцэрлэгийн барилгын өргөтгөл, 100 ор /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 4 дүгээр хороо, 145 дугаар цэцэрлэг/ | БШУС | 1,265 | 370 |
| XIII.1.1.234 | Цэцэрлэгийн барилга, 240 ор /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 20 дугаар хороо/ | БШУС | 2,500 | 600 |
| XI.1.1.14 | Хүүхэд, залуучууд, ахмадын хөгжлийн барилга /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 12 дугаар хороо/ | ХНХС | 1,000 | 400 |
| XI.1.1.13 | Хүүхэд, залуучууд, ахмадын хөгжлийн барилга /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 9, 10, 16 дугаар хороо/ | ХНХС | 2,200 | 400 |
| XI.1.1.12 | Хүүхэд, залуучууд, ахмадын хөгжлийн барилга /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 4, 5, 6, 7, 8 дугаар хороо/ | ХНХС | 2,200 | 400 |
| XI.1.1.11 | Хүүхэд, залуучууд, ахмадын хөгжлийн барилга худалдан авах /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг 1, 2, 19, 20 дугаар хороо/ | ХНХС | 1,600 | 800 |
| XI.1.1.10 | Спорт заал бүхий "Иргэдийн хөгжлийн төв"-ийн барилга /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 9, 10, 16 дугаар хороо/ | ХНХС | 2,200 | 750 |

Худалдан авах ажиллагааны цахим системийг ашигласан байдал:

Хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4 дэх хэсэгт захиалагч тендер шалгаруулалт бүрийн урилга, үр дүнг цахим сүлжээнд тухай бүр зарлахаар хуульчилсан. Монгол Улсын Засгийн газраас төрийн болон орон нутгийн төсвийг үр ашигтай захиран зарцуулах, худалдан авах ажиллагааг хурдан шуурхай, олон нийтэд хүртээмжтэй, ил тод, нээлттэй зохион байгуулах, түүнд олон нийтийн хяналт тавих мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх зорилгоор Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем /www.tender.gov.mn/-ийг боловсруулан 2017 оноос бүх шатны төрийн байгууллагууд худалдан авах ажиллагаа зохион байгуулахдаа ашиглаж байна.

Тайлант хугацаанд нийт 21,586 тендер шалгаруулалт буюу 99.3 хувийг цахим системээр зохион байгуулсан байна.

2021 онд худалдан авах ажиллагааны цахим системд 1,416 захиалагч байгууллагаас тендер шалгаруулалт зарлан зохион байгуулснаас худалдан авах ажиллагааны цахим системд давхардсан тоогоор 21,739 цахим тендерийн урилга зарласан байна. Цахим системд 6,642 аж ахуйн нэгж бүртгүүлэн цахим тендер шалгаруулалтад оролцсон байна.

Хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4 дэх хэсэг, Сангийн сайдын 2019 оны 255 дугаар тушаалаар баталсан “Худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулах, холбогдох мэдээллийг зарлан мэдээлэх журам”-ын 3.2.7-д “Үнэлгээний хороо хуулийн 29.1-д заасан мэдэгдэл хүргүүлсэн өдөрт багтаан цахим системд тендер шалгаруулалтын үр дүнг үнэн зөв, бүрэн нийтэлж, шалгарсан тендерт оролцогчийн ирүүлсэн тендерийн нууцлаагүй хэсгийг Сангийн сайдын 2019 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн 132 дугаар тушаалаар батлагдсан “Тендер шалгаруулалтын материалыг тухайн тендерт оролцогчдод ил болгох журам”-ын дагуу ил болгох.” гэж заасан байдаг.

2021 онд зарласан 21,739 цахим тендер шалгаруулалтаас 20,788 тендер шалгаруулалтын үр дүн 91 хувийг олон нийтэд мэдээлэн ажилласан байна. Захиалагч байгууллагууд тендер шалгаруулалтын урилгыг зарлаж, цахим тендер шалгаруулалтад тендерт оролцогчд оролцож хэвшсэн байгаа хэдий ч тендер шалгаруулалтын үр дүнг шийдвэр гарсан өдөрт нь оруулахгүй зөрчил нийтлэг байна.

Цахим системийн үйл ажиллагааг сайжруулах, улсын хэмжээний тоон мэдээг нэг эх үүсвэрээс авах зорилгоор худалдан авах ажиллагааны явцын болон жилийн эцсийн тайланг системд үндэслэн нэгтгэж байна.


Хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.6 дахь заалтад “гүйцэтгэгчийн гэрээний үүргийн биелэлтэд чанар болон гүйцэтгэлийн хяналт тавьж, явцын мэдээллийг хагас жил тутам худалдан авах ажиллагааны цахим системд оруулах” гэж заасны дагуу худалдан авах ажиллагааны цахим системд захиалагч байгууллагуудыг гэрээний мэдээллийг оруулах боломжийг бүрдүүлсэн бөгөөд 2021 онд 3,768 гэрээний мэдээлэл бүртгэгдээд байна.

Тендерт оролцогч нараас гаргасан гомдлыг шийдвэрлэсэн байдал:

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 54, 55, 56 дугаар зүйлд худалдан авах ажиллагааг зохион байгуулах явцад тендерт оролцогчдын гомдол гаргахдаа аль шатанд ямар байгууллагад хандахыг тодорхой зааж өгсөн байдаг.

Тендер шалгаруулалттай холбоотой 2021 онд нийт 1,207 гомдол холбогдох байгууллагуудад гарсан байх бөгөөд үүнээс 262 гомдол буюу 22 хувь нь тендерийн нээлт хийхээс өмнөх шатанд, 870 буюу 72 хувь нь захиалагчийн шийдвэрт, 75 буюу 6 хувь нь гэрээнд гарын үсэг зурагдсаны дараа эсвэл Сангийн яамны шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй үндэслэлээр шүүхэд тус тус хандсан байна.


Гомдол шийдвэрлэлт



Сангийн яаманд тендерт оролцогч тендерийн баталгаагаа барьцаалан үндэслэл бүхий гомдол гаргах хуулийн зохицуулалтын дагуу 2021 онд 41 үндэслэлгүй гомдолд барьцаалсан 209,700,613.93 төгрөг бүхий тендерийн баталгааг улсын орлого болгох шийдвэр гаргаж, Төрийн сангийн 100900000753 тоот “Тендерийн баталгааны орлого” дансанд төвлөрүүлсэн байна.

Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь гэрээ байгуулах эрх олгосноос хойш ажлын 5 хоногийн дотор тендерт оролцогч нараас ирүүлсэн гомдлыг хүлээн авч 14 хоногт хянан хариу өгдөг.

Сангийн яам тендер шалгаруулалтын үнэлгээг хуульд нийцүүлэн дахин хийх 495 шийдвэр, үүнээс тендер шалгаруулалтыг хүчингүй болгох 55 шийдвэрийг захиалагч байгууллагад хүргүүлж, захиалагч буруу шийдвэр гаргасан байсныг тендерт оролцогчдын хяналтаар дамжуулан зохих шатанд нь залруулсан байна.



Сангийн яаманд давхардаагүй тоогоор 782 тендер шалгаруулалтын үнэлгээтэй холбогдуулан 491 аж ахуйн нэгжээс нийт 870 гомдлыг ирүүлсэн.

Тендерт оролцогчоос захиалагчийн шийдвэрт гаргасан гомдлын 63 хувь нь үндэслэлтэй байна.

| | 2018 | 2019* | 2020 | 2021 |
|--|--------------|--------------|--------------|------------|
| Нийт тендер шалгаруулалт | 5,694 | 13,837 | 22,598 | 22,334 |
| Гомдол | 1,187 | 1,060 | 1,009 | 870 |
| Хувь | 21% | 8% | 4% | 4% |
| Үндэслэлтэй гомдол | 639 54% | 572 54% | 590 58% | 550 63% |
| Үүнээс: Улсын төсвийн хөрөнгө оруулалт | | | | |
| Гомдол | | 151 | 55 | 44 |
| Хувь | | 14.2% | 5.4% | 8.0% |

Энэ нь үнэлгээний хорооны гишүүд тендер шалгаруулалтын үнэлгээг хийхдээ зохих хууль тогтоомжийг мөрдлөг болгон ажиллаагүй, нөгөө талаас захиалагч үнэлгээний хорооны үйл ажиллагаа, үнэлгээний дүгнэлт хуульд нийцсэн эсэхэд хяналт тавьж, гарсан зөрчлийг арилгуулах үүргээ хангалтгүй хэрэгжүүлж байгаатай холбоотой гэж дүгнэж байна.

Цаашид захиалагч хуулийн 46 дугаар зүйлд заасан үүргийг хангалттай хэмжээнд хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна.

Гомдол шийдвэрлэлтийн бусад төрөлд Сангийн яам гомдол гаргах хугацаанд тус яаманд хандаагүй, захиалагч байгууллага гэрээ байгуулсан, эсхүл гаргасан гомдлыг эргүүлэн татсан шийдвэрүүдийг багтаасан. Хуулийн 55 дугаар зүйлийн 55.2 дахь хэсэгт “Шийдвэрлэж хариу өгсөн асуудлаар тендерт оролцогч дахин гомдол гаргасан тохиолдолд хүлээн авахаас татгалзана.” гэж заасны дагуу буцаасан болон шүүхэд хандах 106 гомдол, гаргасан гомдлыг эргүүлэн татсан 42, захиалагчид гомдол гаргах 18 гомдол байсан болно.

Тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлийн талаар:

Засгийн газрын 2019 оны 274 дүгээр тогтоолоор “Худалдан авах ажиллагааны улсын байцаагчийн дүрэм” болон “Тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлийг хөтлөх журам”-ыг баталж хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.4, 14.1.6, 14.1.7 дахь заалтад заасан нөхцөл үүссэн эсэхийг улсын байцаагчаар дамжуулан хяналт шалгалт хийх ажлын хүрээнд Худалдан авах ажиллагааны ерөнхий байцаагчийн удирдамжийн дагуу захиалагч байгууллага, аж ахуйн нэгжээс ирсэн нотлох баримт дээр үндэслэн 2021 онд 16 аж ахуйн нэгжийг тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлд хамруулж, нийт 46 компанийн жагсаалтыг Сангийн яам болон Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем /<https://www.tender.gov.mn/mn/bidder/blacklist/>-д мэдээлэн ажиллаж байна.

Худалдан авах ажиллагаанд оролцогч аж ахуйн нэгжүүдээс тендер шалгаруулалтад бүрдүүлж байгаа баримт, мэдээллийг мэдээллийн сангаас шууд авч тендерийн үнэлгээнд харгалзан үзэхийг Сангийн сайдын 2019 оны 255 дугаар тушаалаар баталсан “Худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулах, холбогдох мэдээллийг зарлан мэдээлэх журам”-аар зохицуулсан. Энэ хүрээнд худалдан авах ажиллагааны цахим системийг хуулийн этгээдийн бүртгэл, татвар төлөгчдийн мэдээллийн сан, санхүүгийн цахим тайлангийн систем, тээврийн хэрэгсэл эзэмшигчдийн бүртгэл, дээд боловсролын гэрчилгээ эзэмшигчд бүртгэл, барилгын тусгай зөвшөөрлийн бүртгэл, нийгмийн даатгалын бүртгэлийн мэдээллийн сан, арилжааны банкны баталгааны бүртгэл, тоон гарын үсгийн бүртгэлийн систем, шүүхийн шийдвэр, шүүхийн төрөлжсөн архивын бүртгэлтэй холбож тендерийн үнэлгээнд харгалзан үзэж байна.

Тайлант хугацаанд нийт 112,554 удаа санхүүгийн тайлангийн лавлагаа, 119,527 татварын тодорхойлолт, 9,848 авто тээврийн лавлагааг татан авч тендерийн үнэлгээнд харгалзан үзсэн байна.

Төрийн мэдээллийн сангуудын холболтыг бүрэн хэрэгжүүлснээр тендерт оролцогчийн бүрдүүлэх материалыг 70 хүртэл хувиар бууруулахаар ажиллаж

байна. Тендерт оролцогчдын бүртгэлийг сайжруулснаар хуурамч баримт бүрдүүлэн тендерт оролцох байдлыг бүрэн хална гэж үзэж байна.

Цаашид худалдан авах ажиллагааны цахим системийг шилэн данс, төрийн сан, төсвийн хөрөнгө оруулалтын мэдээллийн систем холбож гэрээний гүйцэтгэл, гэрээний санхүүжилтийг олон нийтэд ил тод мэдээлэх боломжийг оруулах боломжийг олгоно.

Худалдан авах ажиллагааны сургалтын талаар:

Хуулийн 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсэгт заасны дагуу үнэлгээний хорооны гишүүдэд худалдан авах ажиллагааны мэргэшүүлэх сургалтыг тогтмол зохион байгуулж байна. 2021 онд худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх А-3 сургалтын шалгалтад 10,067 суралцагч бүртгүүлж, 316 удаагийн шалгалтад 4,787 суралцагч тэнцэж нийт гэрчилгээ эзэмшигчдийн тоо 13,444 болсон.

Хуулиар үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд хоёроос доошгүй хөндлөнгийн төлөөлөл, орон нутагт иргэнийг оролцуулан худалдан авах ажиллагааг зохион байгуулах зохицуулалтыг тусгасан байдаг.

Захиалагч байгууллагууд өөрийн худалдан авах ажиллагаанд хөндлөнгийн төлөөлөл оруулах этгээдийн нөөц хангалтгүйгээс 457 үнэлгээний хорооны гишүүнээр ажилласан төрийн бус байгууллагын төлөөлөл байна. Цахим системд үнэлгээний хорооны гишүүдийг бүртгэсэн бүртгэлээс үзэхэд 2021 онд 40-өөс дээш үнэлгээний хороонд томилогдон ажилласан 207 худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан байна.

Худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан үнэлгээний хорооны гишүүнээр олон давтамжтайгаар ажиллах нь тухайн үнэлгээний хорооны үйл ажиллагаанд оролцох боломж хязгаарлаж, сонирхлын зөрчилд өртөх эрсдэлтэй байна. Нөгөө талаас үнэлгээний хорооны хуралд оролцохгүйгээр гарын үсэг зурах зөрчил нийтлэг байна.

Худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтны гэрчилгээг цаасаар олгохыг зогсоож зөвхөн цахим систем /www.tender.gov.mn/mn/exam/certificate/-ээр дамжуулан шалгалтад тэнцсэн тухайн өдрөө гэрчилгээг гардан авах боломжтой болсон. Гэрчилгээг системээр дамжуулан олгох нь Төрийн худалдан авах ажиллагааны газар болон гэрчилгээ авахаар ирдэг иргэдийн зардал, ачааллыг бууруулж байна.

Түүнчлэн хуулийн 47 дугаар зүйлийн 47.5 дахь хэсэгт үнэлгээний хороонд орж ажиллах иргэн, төрийн бус байгууллагын төлөөллийг тэднийг төрийн зардлаар мэргэшүүлж сургах ажлын хүрээнд Дэлхийн банкны дэмжлэгтэйгээр Цахим сургалтын систем /www.surgalt.tender.gov.mn/-ийг ашиглалтад оруулан, сургалтыг зохион байгуулж байна.

Сангийн сайдын 2019 оны 37 дугаар тушаалаар баталсан “Худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх, гэрчилгээ олгох журам”-д гэрчилгээний хүчинтэй байх хугацаа дууссан ажилтнууд давтан танхимын сургалтад хамрагдалгүйгээр хугацааг сунгах боломжийг олгосон.

Төрийн худалдан авах ажиллагааны цахим сургалтын систем /surgalt.tender.gov.mn/-ээр бие даан, үнэ төлбөргүйгээр хичээл үзсэн 351 хүнээс 33 удаагийн цахим шалгалт авсан бөгөөд 212 суралцагч шалгалтад тэнцсэн.

Ерөнхий гэрээний хэрэгжилтийн талаар:

Хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.23, 53 дугаар зүйлийн 53.5.7 дахь заалтад заасны дагуу Төрийн худалдан авах ажиллагааны газраас ерөнхий гэрээний сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, цахим дэлгүүрийн системд байршуулсан.

Шинээр 53 нэр, төрлийн бараа үйлчилгээг ерөнхий гэрээнд оруулж, цахим дэлгүүрт 771 нэр төрлийн бараа, үйлчилгээг ерөнхий гэрээний журмаар зохион байгуулсан байна.

2021 онд хуулийн үйлчлэх хүрээнд хамаарах 224 захиалагч байгууллагаас 118 нэр төрлийн бараа, үйлчилгээг 54.5 тэрбум төгрөгөөр худалдан авлаа.

Ерөнхий гэрээ нэгж үнийн дээд хязгаараас хоёр дахь шатны сонгон шалгаруулалтын дагуу худалдан авсан нийт үнэ буюу 13.2 тэрбум төгрөгийн хэмнэлт үүссэн байна.

Ерөнхий гэрээ байгуулсан бараа, үйлчилгээнээс хоёр дахь шатны сонгон шалгаруулалтын дагуу хамгийн их хэмжээгээр худалдан авсан 15 нэр төрлийн барааг дараах хүснэгтээр үзүүлж байна.

Ерөнхий гэрээний дагуу худалдан авсан барааны дүн /захиалгын дүнгээр - эхний 15 /

| № | Бүтээгдэхүүний нэр | Захиалгын тоо | Захиалгын дүн | Хэмнэлт |
|----------|--|----------------------|----------------------|----------------|
| 1 | Ремдесивир /100мг-тариа/ | 92,529 | 8,118,020,800 | 3,540,633,200 |
| 2 | AG COVID-19 RAPID TEST /Хамар залгиурын/ | 580,411 | 6,533,411,500 | 1,302,137,000 |
| 3 | nCoV-2 ПГУ оношлуур дагалдах хэрэгслийн хамт /бамбар, орчин, ПГУ тюрб/ | 433,197 | 4,945,990,140 | 1,547,632,890 |
| 4 | Натрийн хлорид 0.9%-100мл | 1,635,896 | 2,035,708,360 | 9,161,640 |
| 5 | Автомат аргаар нуклейн хүчил ялгах кит (magnetic beads method) дагалдах хэрэгслүүд | 175,257 | 1,752,570,000 | 0 |
| 6 | Левовфлоксацин 5мг/мл-100мл | 149,899 | 1,609,478,970 | 189,309,030 |
| 7 | Цефотаксим 1гр | 1,716,138 | 1,596,008,340 | 0 |
| 8 | Меропенем 1000мг | 65,799 | 1,584,581,000 | 718,384,000 |
| 9 | Арбидол /Умифеновир-100мг/ | 1,827,031 | 1,405,119,580 | 1,335,426,920 |
| 10 | Гөлгөр шар цаастай, оёотой, 84x108/16 форматын сурах бичиг хэвлэх нийлүүлэх | 63,295,740 | 1,379,436,117 | 159,283,323 |
| 11 | Сурагч ширээ | 8,000 | 1,199,992,000 | 8,000 |
| 12 | Цефазолин | 1,531,081 | 1,193,892,680 | 350,500 |
| 13 | Натрийн хлорид 0.9%-500мл | 742,454 | 1,167,963,080 | 5,114,240 |
| 14 | Натрихлорид 0.9% - 200мл, 250мл | 860,456 | 1,027,439,055 | 5,108,145 |
| 15 | Фавипиравир /Авиган-200мг/ | 809,971 | 1,013,091,500 | 2,631,778,000 |

Төсвийн ерөнхийлөн захирагчдын тайланд өгсөн нэгдсэн зөвлөмж:

Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2021 оны худалдан авах ажиллагааны хэрэгжилтэд дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

1.Цахим системд 2021 онд хэрэгжүүлэхээр 27,969 худалдан авах ажиллагаа төлөвлөсөн боловч 22,334 төсөл, арга хэмжээг зохион байгуулснаас үзэхэд худалдан авах ажиллагааны төлөвлөлт бодитой бус, тухайн онд хэрэгжихгүй төсөл, арга хэмжээг олноор төлөвлөж байгаа нь төлөвлөлт, гүйцэтгэл зөрөх үндсэн шалтгаан болж байна;

2.Цахим системд 2021 онд 22,334 тендер шалгаруулалтын урилгыг нийтэлснээс 21,982 тендер шалгаруулалтын үр дүн нийтэлсэн ба хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4 дэх хэсгийг зөрчиж тендер шалгаруулалтын үр дүнг олон нийтэд нийтлэхгүй байх, хугацаа хоцроох буюу жилийн төгсгөлд мэдээлж байна;

3.Гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, гэрээний гүйцэтгэлийн явцад гарсан аливаа зөрчлийг арилгаж, гэрээнд заасан хугацаанд үүргийн гүйцэтгэлийг хангаж, гэрээний үүргээ зөрчсөн аж ахуйн нэгжийн талаарх мэдээллийг хуулийн 14 дүгээр зүйлд заасны дагуу нотлох баримтын хамт тухай бүр ирүүлдэггүй;

4.Сангийн яаманд ирсэн гомдлын дийлэнх буюу 63 хувь нь захиалагч хууль зөрчсөн шийдвэр гаргасан гэсэн хариу гарч байгаагаас дүгнэхэд үнэлгээний хороо тендер шалгаруулалтын үнэлгээг хийхдээ хууль, журмыг зөрчсөн, үндэслэлгүй шийдвэр гаргах, түүнд захиалагчийн зүгээс хяналт тавихгүй байгаа нь захиалагч хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.2 дахь заалтын биелэлт хангалтгүй;

5.Улирлын чанартай төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг төлөвлөгөөнд заасан хугацаандаа зохион байгуулахгүй байгаа нийтлэг зөрчил нь хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.8 дахь заалттай нийцэхгүй байгааг анхаарч ажиллах шаардлагатай байна.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

ТӨСВИЙН ЗАХИРАГЧ НАРТ

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн хуралдааны 16 дугаар тэмдэглэлд:

“ХҮИИ.17. Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2022 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн худалдан авах ажиллагааны явцын талаар Сангийн сайд Б.Жавхлан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан:


1. Ерөнхий сайдын 2022 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн 2 дугаар албан даалгавраар өгөгдсөн Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар батлагдсан Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг 2022 оны 3 дугаар сарын 1-ний өдрийн дотор зарласан байх үүргийн хэрэгжилт Улаанбаатар хотод хэрэгжих төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны хувьд хангалтгүй байгаа тул уг асуудалд анхаарал хандуулах, эрчимжүүлж ажиллахыг Нийслэлийн Засаг дарга Д.Сумъяабазарт даалгав;

2. Тендер шалгаруулалтын үнэлгээг хуульд нийцүүлэн шуурхай зохион байгуулж, тендер шалгаруулалтын үр дүнд шалгарсан гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг худалдан авах ажиллагааны цахим системд оруулж, ажиллахыг Төсвийн шууд захирагч нарт даалгав;

3. Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн төсөлд техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгахыг Төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгав;

4. Худалдан авах ажиллагааны цахим системийн үйл ажиллагааг бусад мэдээллийн системтэй холбох ажлын явцын талаар танилцуулахыг Сангийн сайд Б.Жавхланд даалгав;

5. Аймаг, орон нутагт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны хэрэгжилт, явцын талаар 2022 оны 4 дүгээр сарын 6-ны өдрийн Засгийн газрын хуралдаанд Аймаг, нийслэлийн Засаг нартай хамтарсан цахим уулзалт зохион байгуулж, танилцуулахыг Сангийн сайд Б.Жавхлан, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдорж нарт даалгав.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР